



ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 08 сарын 13 өдөр

Дугаар А143

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 46.2 дахь хэсэг, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус компанид 0.4 кВ-н 2-р хуваарилах байгууламжийг иж бүрэн шинэчлэх ажил гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог дараах бүрэлдхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга:	Б.Мягмаржав /Тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер/
Нарийн бичгийн дарга:	М.Энхбат /Худалдан авах ажиллагааны ахлах мэргэжилтэн/
Гишүүд:	Г.Болдсайхан /Хангамж, үйлчилгээ хариуцсан дэд захирал/ Ц.Батбаатар /Техникийн бодлого төлөвлөлт, шуурхай ажиллагааны албаны дарга/ С.Батсайхан /Цахилгаан, дулааны хянах хэмжүүр автоматикийн цехийн дарга/ Ж.Ханд-Иш /Монголын эрчим хүчний мэргэшсэн инженерүүдийн зөвлөлийн гишүүн/ Э.Мөндөр /Монголын эрчим хүчний барилга угсралт, засварчдын холбооны эксперт/

2. Холбогдох хууль, тогтоомж, заавар, журмын дагуу тендерийн бичиг баримтыг бүрдүүлэн тендерийн ажиллагааг явуулж, үнэлгээний хорооны дүгнэлт, зөвлөмжийг захиалагчид танилцуулахыг үнэлгээний хорооны дарга /Б.Мягмаржав/-д үүрэг болгосугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлэх, Үнэлгээний хорооны гишүүдийн мэдэгдэл, тайлбарыг гаргуулан авч компанийн эрх бүхий албан тушаалтанд хугацаанд нь бүртгүүлэхийг нарийн бичгийн дарга /М.Энхбат/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



С.БЯМБААХҮҮ

Tushaal.A4.2019

360000224

